МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн Үндэстний гудамж 5/2, Засгийн газрын II байр,
Утас: 26 19 66, Факс: (976-51) 26 61 71,
И-мэйл: contact@mne.gov.mn, Вэбсайт: www.mne.mn

2022.02.28 № 03/1042

танай _____-ны №_____-т

ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ
АЖИЛЛАГААНЫ ГАЗАРТ

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтад Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2022 онд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтын VI.4.1-д "Богдхан уулын дархан цаазат газрын явган аяллын маршрутын зураг төсөв" (Улаанбаатар, Хан-Уул дүүрэг) боловсруулах гэж баталсан.

Дээрх зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг батлан хүргүүлж байна. Худалдан авах ажиллагааг төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулна уу.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Э.БАТТУЛГА

152290931

БАТЛАВ.
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Э.БАТТУЛГА

БОГДХАН УУЛЫН ДАРХАН ЦААЗАТ ГАЗРЫН ЯВГАН АЯЛЛЫН МАРШРУТЫН ЗУРАГ ТӨСӨВ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2022 оны 02 дугаар сарын 09-ны өдөр Улаанбаатар хот

1.	Үндэслэл:	Сүүлийн жилүүдэд иргэд идэвхтэй амьдралын хэв маягийг эрэлхийлж явган аяллын спорт эрчимтэй хөгжиж байгаа, төр засгаас эрүүл дадал хэвшилтэй, иргэдийнхээ идэвхтэй амьдралын хэв маягийг дэмжсэн ажлуудыг явуулж бодлогын баримт бичгүүддээ тусгасан байдаг. - Алсын хараа 2050 урт хугацааны бодлогын баримт бичгийн 4.2.46-д “Зарим тусгай хамгаалалттай газар нутгийг байгальд ээлтэй эко аялал жуулчлалын зориулалтаар төлөвлөн хөгжүүлнэ” гэж, 6.1.8-д “Тусгай хамгаалалттай газар нутгийн нөөц, даацад тулгуурласан эко аялал жуулчлалыг хөгжүүлнэ” ; - Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 333 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого”-ын 4.4.2. “Байгалийн унаган төрхийг хадгалах, хамгаалах чиглэлээр эко, тогтвортой аялал жуулчлалын бүсүүдийг тогтоож, хөгжүүлнэ”; - Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2022 онд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтын VI.4.1 дэх хэсэгт “Богдхан уулын дархан цаазат газрын явган аяллын маршрутын зураг төсөв /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/”-ийг боловсруулна гэж тусгасан.
2.	Зорилго:	Богдхан уулын экологийн тэнцвэрт байдлыг хамгаалах, явган аялагч нарт тав тухтай орчин бүрдүүлэн байгальд ээлтэй эко аялал жуулчлалыг хөгжүүлэх
3.	Байршил:	Богдхан уулын дархан цаазат газар Хан-Уул дүүрэгт 16556,88 га талбайн Нүхт, Арцат, Хүүш, Түргэн, Ташгай, Жаргалант, Тайны ам болон бусад газар.
4.	Хамрах хүрээ:	Богдхан уулын Дархан цаазат газрын тухайн заасан бүс нутагт явган аяллын маршрут, орчны зураг төсөв ТЭЗҮ боловсруулах. /Хан-Уул дүүрэг/
5.	Ашиглах материал:	Монгол Улсын хуулиуд: - Монгол Улсын Үндсэн хууль - Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль; - Хот байгуулалтын тухай хууль; - Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль - Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль; - Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль; - Соёлын өвийг хамгаалах тухай хууль; - Аялал жуулчлалын тухай хууль; - Ойн тухай хууль

		- Усны тухай хууль; - Хамгаалалтын бүс тогтоох тухай; - Байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай; - Байгаль орчныг хамгаалах тухай хууль; - Байгалийн ургамлын тухай хууль /нэн ховор, ховор ургамлын жагсаалт/, - Амьтны тухай хууль - Гамшгаас хамгаалах тухай хууль; - Галын аюулгүй байдлын тухай хууль; - Газрын тухай хууль; - Барилгын тухай хууль; - Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм - Байгаль хамгаалах олон улсын холбоо /IUCN/-аас гаргасан Тусгай хамгаалалттай газар нутгийн аялал жуулчлал ба аялагчдын удирдлага, зохион байгуулалт "Тогтвортой хөгжлийн удирдамж" гарын авлага, 2020 он - Тусгай хамгаалалттай газар нутагт мөрдөгдөх нэгдсэн өнгө төрх, загварыг батлах тухай БОАЖС-ын 2018 оны А/498 дугаар тушаал - Бусад холбогдох дүрэм журам, стандарт, баримт бичиг, Норм, нормативууд
6.	Баримт бичгийн иж бүрдэл:	- Судалгаа, үнэлгээ тооцооллын аргачлал арга зүй; /Материалд дүн шинжилгээ хийх, судалгааны үр дүнгийн нэгтгэл, иргэд оршин суугч, төлөвлөлтийн бүсэд хийгдсэн судалгаа зэрэг бусад шаардлагатай материал/ - Инженер-геологийн дүгнэлт - Төлөвлөлтийн талаарх танилцуулга - Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын тооцоо Зураглалын бүрдэл: <u>*Судалгаа, үнэлгээ тооцооллын зураглал*</u> - Зургийн жагсаалт, тайлбар бичиг - Байршлын схем М1:25000; - Орчны тойм М1:10000-25000; - Байр зүйн дэвсгэр зураг М1:2000; - Авто зам тээврийн сүлжээ М1:5000; - Барилгажилт М1:5000; - Газар ашиглалтын судалгаа М1:5000; - Газар ашиглалтын бүсчлэл М1:5000; - Түүх соёл, аялал жуулчлал М1:5000; - Гамшгийн менежмент М1:5000; - Ногоон байгууламж, спорт, амралтын талбай М1:5000; - Инженерийн бэлтгэл арга хэмжээ М1:5000; - Дулаан хангамж М1:5000; - Ус хангамж, ариутгах татуурга М1:5000; - Цахилгаан хангамж М1:5000; - Нийгэм-Эдийн засгийн үнэлгээ М1:5000 - Дэд бүтцийн үнэлгээ М1:5000

		- Архитектур, түүх, соёл, археологийн дурсгал, ландшафтын үнэлгээ М1:5000 *<u>Төлөвлөлтийн зураглал</u>* - Зургийн жагсаалт, тайлбар бичиг; - Газрын нэгдмэл сангийн ангилал М1:10000-15000; - Гудамж, замын сүлжээ М1:2000; /батлагдах хуудас/ - Ерөнхий төлөвлөгөөний бүсчлэл М1:2000; /батлагдах хуудас/ - Ерөнхий төлөвлөгөө М1:2000; /батлагдах хуудас/ - Архитектур орон зайн төлөвлөлт, барилгажилт М1:2000; - Газар зохион байгуулалтын төлөвлөлт М1:5000; - Ногоон байгууламж, спорт, амралт, аялал зугаалгын бүс М1:5000; - Соёл, ахуй үйлчилгээний ангилал, үйлчлэх хүрээ М1:5000; - Аялал жуулчлалын менежмент нэгдсэн төлөвлөлт М1:5000 - Тусгай хамгаалалттай бүс хориглох, хязгаарлах дэглэмтэй бүсүүдийн төлөвлөлт М1:5000; - Дугуйн зам, хөсөг тэрэг, явган замын төлөвлөлт М1:5000; - Нийтийн тээврийн нэгдсэн зогсоол, авто машины зогсоол, төлөвлөлт М1:5000; - Аялал жуулчлалын нэгдсэн трасс М1:5000; - Гадна зам тээврийн сүлжээ М1:10000-25000; - Гамшгийн менежмент нэгдсэн төлөвлөлт М1:5000; - Хог хаягдлын нэгдсэн төлөвлөлт М1:5000; - Төлөвлөлтийн үе шатны зураглал М1:5000; - Төлөвлөлтийн хүрээнд шинээр дахин төлөвлөх, сэргээн засварлах, хамгаалалтад авах бүс М1:5000; - Инженерийн бэлтгэл арга хэмжээ, өндөржилт, улаан шугам М1:2000; - Үерийн хамгаалалт, далангийн зураг М1:5000; - Инженерийн дэд бүтцийн хамгаалалтын зурвас М1:5000; - Инженерийн дэд бүтцийн нэгдсэн зураг М1:2000; /батлагдах хуудас/ - Ус хангамж, ариутгах татуурга М1:2000; - Цахилгаан хангамж М1:2000; - Холбоожуулалт М1:2000; - Ерөнхий харагдах байдал /3D зураг/ Тоон материалын бүрдэл: - Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний товч тайлбар 2-3 хуудас байх/*.doc, *.pdf/ - Товч танилцуулга 25-аас ихгүй слайд байх/*.ppt/ - Төлөвлөлтийн онцлогийг харуулсан анимэйшн 2 минутаас багагүй байх./*.mp4; 720HD/ - Ажлын үе шатны зураглалын бүрдэл /*.dwg, *.pdf, *.jpg/ - Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураг төслийн ажлыг хот байгуулалтын нэгдсэн мэдээллийн санд хүлээж авахад тавигдах үндсэн шаардлага болон бусад холбогдох материал тусгах.
7.	Хийгдэх ажил	Архитектур орон зай

		- Тухайн бүс нутгийн хэмжээнд уг төсөл ямар нөлөөлөл үзүүлэх, түүх соёлын ач холбогдлыг тодорхойлох; - Богдхан уул эко бүсэд хэрхэн нөлөөлөх, амьтан ургамлын тархцад үзүүлэх эерэг, сөрөг нөлөөг тооцох; - Түүх соёлын биет өв болон соёлын биет бус өвийг судлан хууль эрх зүйн хүрээнд хамгаалалтад авах арга аргачлалыг тодорхойлох; - Явган аяллын маршрут болгоныг шинээр төлөвлөх (байгалийн рельеф, хөрсний эвдрэл, бороо, үерийн усны гольдрол, нойтон, халтиргаатай үеийн аюулгүй байдал, бүх насны иргэдэд эерэг байх, амрах цэгүүдийн байршил, мэдээллийн самбаруудын байршил зэрэг бусад хүчин зүйлүүдийг тооцох); - Явган аяллын маршрут болгонд дэд бүтцийн цогц шийдэл санал болгох (автомашины зогсоол, ариун цэврийн байгууламж, үйлчилгээний цэг, явган замын тохижуулах ажлууд: явган гүүр, ус зайлуулах суваг, амрах цэгүүд, мэдээ, мэдээллийн самбарууд зэрэг бусад газар) Газар зохион байгуулалт - Төлөвлөлтөөр хийгдсэн авто зам, зогсоол талбайг бусад холбогдох төлөвлөлтөд тусгаж ажиллах. Аялал жуулчлал - Дотоодын аялагч зорчигчдын тоо, жилд үйлчлүүлэх аялагч эрэлт нийлүүлэлтийн хүчин чадлыг судалж төлөвлөлт тусгах. Худалдаа үйлчилгээ - Худалдаа үйлчилгээний салбарын чиглэлийг тодорхойлж, хүчин чадал, хүрэлцээг судалж төлөвлөлтөөр шийдэх; - Тогтвортой үйл ажиллагааг хэвийн явуулах үүднээс тухайн үйлчилгээг хувийн хэвшилтэй хамтран ажиллуулах моделүүдийг боловсруулах. Ногоон байгууламж - Ногоон байгууламжийг цэцэрлэгт хүрээлэн, цэцэрлэгт гудамж, инженерийн дэд бүтцийн хамгаалалтын ногоон байгууламж зэргээр ангилж, норм дүрмийн дагуу төлөвлөх; - Ногоон байгууламжид хэрэглэх мод, бут сөөг болон ургамлыг байршлыг төлөвлөх. - Байгалийн тогтцыг ашиглан ус хуримтлуулах усан толио үүсгэх замаар бичил уур амьсгалыг бүрдүүлэх; - Амралт зугаалга, аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлийн хүрээнд улсын тусгай хамгаалалттай газар нутагт мөрдөгдөх нэгдсэн өнгө төрхөд нийцүүлсэн тохижилт бүхий цэцэрлэгт хүрээлэнг төлөвлөх; - Цэцэрлэгжүүлэлтийг хүн амын ажиллаж амьдрахад тохиромжтой гоо зүй, ариун цэвэр-эрүүл ахуйн нөхцөлийг хангасан, орон зайн бичил уур амьсгалын тааламжтай

		орчинг бий болгож хүний үйл ажиллагааны элдэв хортой нөлөөллөөс хамгаалах, нутаг дэвсгэрийн архитектур-орон зайн зохиомжийг сайжруулсан байхаар тооцож төлөвлөх; Хог хаягдал - Хог хаягдлын цэгүүд болон төвлөрүүлэх газруудын байршлыг тодруулж, тулгамдаж буй асуудлыг тодорхойлох; - Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, зайлуулах, дахин ашиглах, устгах, тусгай цэг байгуулах менежментийн төлөвлөлтийг боловсруулж тусгах; Гамшгийн менежмент - Гамшгийн үед авах арга хэмжээний төлөвлөгөө, шаардлагатай тохиолдолд үйлчлэх онцгой байдлын газар, гал унтраах ангийн хамрах хүрээ, аюулын дуут дохио, хорогдох байр, түр цуглах талбайн судалгаа гаргаж, хүчин чадал, хүрэлцээг одоогийн байдлаар тодорхойлох; - Гамшгийн аюулд өртөх магадлалтай газар нутаг, айл өрх, эдэлбэр газрын судалгааг гаргаж төлөвлөлтөд тусгах; Инженерийн бэлтгэл арга хэмжээ - Одоо байгаа ундны усны эх үүсвэрийн хамгаалалт, хориглолт, хязгаарлалтын бүс, үерийн далан суваг, байгалийн жалга, борооны болон гадаргын ус зайлуулах шугам сүлжээний хамгаалалт, хориглолт, хязгаарлалтын бүсүүдийг тодорхойлох; - Төлөвлөлтөөр хийгдсэн гуу жалга, ус зайлуулах далан шуудууны тоо хүчин чадлыг дахин тооцоолон судалж дараагийн төлөвлөлтөд тусгах; Дулаан хангамж - Дулааны эх үүсвэрийг судлах - Инженерийн шугам сүлжээний төлөвлөлтийг судлах Усан хангамж - Төлөвлөлтийн шатанд ундны усны эх үүсвэрийн хориглолт, хамгаалалтын мужийн байршил, эрүүл ахуйн дэглэмийн заалтуудыг нарийн мөрдөх; - Усны хэрэглээний нэгдсэн тооцоог төлөвлөлтийн үе шатаар нарийвчлан хийх, хэрэглэгчийн шугамыг дулааны шугамтай хамт бүсчилсэн байдлаар төлөвлөх, /хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд үе шат заасан нөхцөлд тухайн үе шатаар дэлгэрэнгүй тооцоо хийх\ - Батлагдсан ажлын зураг төсөлтэй уялдуулан төлөвлөх, шугамын трасс хүчин чадал, төсөвт өртөг зэргийг тодорхой тусгах, хөрөнгө оруулалтын тооцоог батлагдсан нормын дагуу төлөвлөх; - Усны дахин ашиглалт /саарал ус/-ыг нэмэгдүүлэх, хур тунадасны ус хуримтлуулах, газрын гадарга дээрх цэвэр усны нөөцийг ашиглах, усны хэрэглээг багасгах боломжит хувилбаруудыг боловсруулах;

		Ариутгах татуурга - Ариутгах татуургын шугам сүлжээний трассыг сонгохдоо гидрогеологийн хайгуул дүгнэлт, ундны усны хамгаалалтын бүсийн дэглэмийн журмыг тооцож төлөвлөх; - Инженерийн шугам сүлжээний төлөвлөлт бусад дэд бүтцийн шугам сүлжээтэй уялдаж байхаар төлөвлөх; - Гадаргын болон хөрсний усны шугам сүлжээний шийдэлтэй уялдуулах; Ариун цэврийн байгууламж - MNS 4943:2015, Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага хангасан цэвэрлэх байгууламж - "Ахуйн бохир ус цэвэрлэх зохиомол биологийн цэвэрлэгээний бага хүч чадлын цэвэрлэх байгууламж"–ын барилгын хийцийн зураг болон БНбД 40-0106 барилгын норм дүрэм зэрэг бусад стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийг төлөвлөх Цахилгаан хангамж - Цахилгаан эрчим хүчний эх үүсвэрийг тодорхойлж, дамжуулах болон түгээх шугам сүлжээ, дэд станцуудын хүчин чадал, насжилт, дамжуулах чадварын тооцоог хийх; - Хуваарилах байгууламж, дэд станцын байршлыг инженер-геологийн судалгаатай уялдуулан төлөвлөх; - Цахилгааны байгууламжууд, шугам сүлжээний хамгаалалтын зурвасыг тогтоох; - Цахилгаан хангамжийн бие даасан эх үүсвэр төлөвлөх, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээс хангагдах хэсгийн мэдээлэл, эх үүсвэрийн хүчин чадал, ачааллыг гаргаж тусгах; Мэдээлэл холбоо - Харилцаа холбооны станцын байршил, дамжуулах сүлжээ, технологийн шийдэл, барилга байгууламжийн хэмжээ, хүчин чадлыг гаргах; - Худаг сувагчлал, кабелийн байгууламжийн төлөвлөлт, хүчин чадал, хамрах хүрээг төлөвлөх; - Үүрэн холбооны станцыг өндөржилтийн төлөвлөлттэй уялдуулан дамжуулах сүлжээтэй хамт төлөвлөх; - Гамшгийн үед зарлан мэдээлэх системийн төлөвлөлт хийх - Шилэн кабелийн сүлжээний мэдээллийг гаргах;
8.	Тусгай шаардлага:	- Богдхан уулын тухайн бүсэд экологийн тэнцвэрт байдал, нөөц баялгийг хадгалан авч үлдэх, байгаль орчны онцгой хамгаалалтын бүсүүдийг тогтоох, түүх соёл архитектурын дурсгалыг хамгаалах, эрүүл ахуй, галын аюулгүйн шаардлагыг хангах хамгаалах арга замыг тусгах,

		- Тухайн нутаг дэвсгэрт ажиллаж, амьдарч буй иргэдээс төлөвлөлтөд тусгах зорилгоор санал асуулга, судалгаа явуулсан байх; - Аялал жуулчлалын маршрут, дэд бүтцийн хангамжийг шийдвэрлэх, төлөвлөлт хийхдээ мэргэжлийн байгууллагуудтай зөвшилцөх, урьдчилсан байдлаар санал авсан байх шаардлагатай; - Авто зогсоол, явган зам, унадаг дугуйн зам, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зам талбай төлөвлөх, тохижилтын ажлын зураг хийх; - Ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх талбайг бэлтгэх, хэрэгжүүлэх арга замыг судлан тусгах; - Төлөвлөлтийн шийдлийг эх загвар зураг, эскизийн шатанд зөвшилцөх; - Шинээр боловсруулах ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг өмнө нь хийгдсэн ерөнхий төлөвлөгөөнүүдтэй уялдуулан нэгдсэн шийдэл гаргах; - Зураг төслийг экспертизээр оруулж хянуулах. - Макет III зэрэг (Ерөнхий төлөвлөгөө, ХЕТ) - Авто болон явган аялагчийн нэвтрэх хаалтыг хийхдээ олон улсын жишигт нийцсэн шийдлүүдээс боломжит хувилбарыг сонгох, нэвтрэх хураамжийн төлбөрийг ухаалаг системээр шийдэх арга зам, аргачлалыг гаргах. - Ууланд аялах аяллын дүрэм боловсруулж сайдын зөвлөлийн хурлаар батлуулах - Нэн ховор, ховор амьтан, ургамлын жагсаалт, байршлыг 6, 7, 8 дугаар саруудад үзэж болох ургамлын жагсаалтыг нарийвчлан гаргах - Дээд, доод ургамлын ангилал зүй, зүйлийн бүрэлдэхүүнийг ам тус бүрээр гаргах, холбогдох эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран ажиллах. - Аяллын маршрутыг ховор Амьтан, Ургамалын нягтшил бага газраар төлөвлөх. - Олон улсын стандартын дагуу явган аяллын маршрутыг байгальд ээлтэй байдлаар тохижуулах - Судалгааны дагуу гарсан материалыг ашиглан мэдээ, мэдээллийн самбарууд төлөвлөх. - Явган болон дугуйн аяллын зам дагуух замын тэмдэг, тэмдэглэгээг төлөвлөх. - Явган болон дугуйн маршрутын газрын зураг гаргах (нийт урт, хир налуу, хөрсний бүтэц, амралтын цэгүүдийн хоорондын зай гэх мэт мэдээлэл агуулсан). - Явган аяллын болон дугуйн замууд давхцахгүй байх.
9.	Боловсруулах хугацаа, тайлангийн бүрдэл:	Захиалагч, гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээгээр гүйцэтгэх хугацааг үндэслэл болгоно. Эхлэлийн тайлан: - Одоогийн байдлын төлөв байдлын судалгаа, байр зүйн зураглал, инженер геологи, түүхэн барилга байгууламжийн судалгаа дуусан байх, одоогийн байдалд үнэлэлт дүгнэлт

		хийх, аялал жуулчлалын бүс нутгийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төлөвлөлтийн тооцоолол боловсруулах; - Дундын тайлан: Эхлэлийн тайланд өгсөн саналыг тусгаж төлөвлөлтийн үе шатанд тавигдах шаардлагын дагуу зураг төсвийг хийж гүйцэтгэсэн байх; - Төлөвлөлтийн шийдлийг олон нийтэд танилцуулж хэлэлцүүлэг хийх /Мэргэжлийн байгууллагууд болон төр захиргааны байгууллагуудад танилцуулж хэлэлцүүлэг хийх/ Эцсийн тайлан:Сайдын зөвлөлийн хуралд танилцуулах хурлаас гарсан санал, дүгнэлтийг тусгаж, эцсийн байдлаар хүлээлгэн өгөх;
10.	Захиалагч байгууллага	Байгаль орчин, аялал жуулчлалын яам,

ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ А.ЭНХБАТ

ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ БҮС НУТГИЙН УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.БАТМӨНХ

БОЛОВСРУУЛСАН:
АЖБЗГ-Н МЭРГЭЖИЛТЭН Б.ОДБАЯР